



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хялганат тосгоны Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/104/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр: Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 76.

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХЯЛГАНАТ ТОСГОНЫ СОЁЛЫН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Д.БАТХУЯГ  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хялганат тосгоны Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хялганат тосгоны Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:/bichighereg/2022A4toot

006020100

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС      Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС      Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ      Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,632,950.00</b>	<b>4,365,400.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	5,632,950.00	4,365,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,405,250.00	4,365,400.00
35410	Бичиг хэргийн материал	1,167,250.00	394,700.00
35420	Аж ахуйн материал	3,743,000.00	3,970,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>81,674,415.98</b>	<b>71,275,756.94</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	81,674,415.98	71,275,756.94
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	73,230,416.06	62,129,534.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	72,048,192.46	72,048,192.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,929,641.12)	(26,894,461.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,333,028.70	14,333,028.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,274,477.46)	(12,829,374.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,481,171.76	22,481,171.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,650,115.28)	(15,439,828.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,972,257.00	5,972,257.00
39217	Ном	2,250,000.00	2,458,550.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,443,999.92	9,146,222.08
39301	Програм хангамж	150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(90,000.08)	(387,777.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,384,000.00	8,384,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>87,307,365.98</b>	<b>75,641,156.94</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>87,307,365.98</b>	<b>75,641,156.94</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	87,307,365.98	75,641,156.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	288,357,982.94	288,357,982.94
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(280,989,820.83)	(292,656,029.87)
51210	Өмнөх үеийн үр дүн	(280,989,820.83)	(280,989,820.83)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,666,209.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	79,939,203.87	79,939,203.87
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>87,307,365.98</b>	<b>75,641,156.94</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>94,149,400.00</b>	<b>91,261,850.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>573,500.00</b>	<b>708,550.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	573,500.00	708,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	573,500.00	708,550.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	573,500.00	500,000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		208,550.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>93,575,900.00</b>	<b>90,553,300.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	93,575,900.00	90,553,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,575,900.00	90,553,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>105,423,642.64</b>	<b>102,928,059.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>105,423,642.64</b>	<b>102,928,059.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	96,819,750.17	100,884,572.09
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	41,673,669.03	43,617,497.65

**Хялганат тосгоны Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210101	Үндсэн цалин	33,219,102.33	37,324,062.90
210102	Нэмэгдэл	8,454,566.70	6,293,434.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,977,738.50</b>	<b>5,453,811.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,510,238.07	3,880,801.48
210202	Тэтгэмжийн даатгал	413,382.77	432,565.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	330,713.03	346,051.83
210204	Ажилгүйдлийн даатгал	64,479.79	70,933.09
210205	Эрүүл мэндийн даатгал	658,924.84	723,459.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,439,600.00</b>	<b>36,293,804.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	539,600.00	397,198.40
210302	Түлш, халаалт	35,900,000.00	35,896,606.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>313,560.00</b>	<b>1,592,550.00</b>
210401	Бичиг хэрэг	67,760.00	73,300.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	79,300.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	90,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,254,250.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>90,000.00</b>	<b>379,700.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	90,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	-	299,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>40,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	40,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,507,000.00</b>	<b>1,900,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,399,000.00	1,900,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,773,182.64</b>	<b>11,607,209.04</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,773,182.64	11,607,209.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,603,892.47</b>	<b>2,043,486.95</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>250,000.00</b>	<b>200,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,353,892.47</b>	<b>1,843,486.95</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,353,892.47	1,843,486.95
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(11,274,242.64)</b>	<b>(11,666,209.04)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(11,274,242.64)</b>	<b>(11,666,209.04)</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,357,982.94	79,939,203.87	(269,715,578.19)		98,581,608.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>288,357,982.94</b>	<b>79,939,203.87</b>	<b>(269,715,578.19)</b>	-	98,581,608.62
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,274,242.64)		(11,274,242.64)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,357,982.94	79,939,203.87	(280,989,820.83)	-	87,307,365.98
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	288,357,982.94	79,939,203.87	(280,989,820.83)	-	87,307,365.98
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>288,357,982.94</b>	<b>79,939,203.87</b>	<b>(280,989,820.83)</b>	-	87,307,365.98
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,666,209.04)		(11,666,209.04)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,357,982.94	79,939,203.87	(292,656,029.87)	-	75,641,156.94

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>94,149,400.00</b>	<b>91,053,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>573,500.00</b>	<b>500,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	573,500.00	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	573,500.00	500,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	573,500.00	500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>93,575,900.00</b>	<b>90,553,300.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	93,575,900.00	90,553,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,575,900.00	90,553,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>94,149,400.00</b>	<b>90,053,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>94,149,400.00</b>	<b>90,053,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>85,545,507.53</b>	<b>88,009,813.05</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	41,673,669.03	43,617,497.65
210101	Үндсэн цалин	33,219,102.33	37,324,062.90
210102	Нэмэгдэл	8,454,566.70	6,293,434.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,977,738.50	5,453,811.00
210201	Тэтгэврийн даатгал	3,510,238.07	3,880,801.48
210202	Тэтгэмжийн даатгал	413,382.77	432,565.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	330,713.03	346,051.83
210204	Ажилгүйдлийн даатгал	64,479.79	70,933.09
210205	Эрүүл мэндийн даатгал	658,924.84	723,459.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,439,600.00	36,293,804.40
210301	Гэрэл, цахилгаан	539,600.00	397,198.40
210302	Түлш, халаалт	35,900,000.00	35,896,606.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	311,500.00	325,000.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	90,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	390,000.00	379,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	90,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	299,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	40,000.00
210702	Дотоод албан томилолт	-	40,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,708,000.00	1,900,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,600,000.00	1,900,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,603,892.47</b>	<b>2,043,486.95</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	250,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	8,353,892.47	1,843,486.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,353,892.47	1,843,486.95
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	-	<b>1,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>1,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>1,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	1,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	1,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b>(1,000,000.00)</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	0.00	91053300.00	89209813.05
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	91053300.00	88209813.05
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	90853300.00	88009813.05
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	0.00	44619100.00	43617497.65
210101	Үндсэн цалин	0.00	0.00	38143600.00	37324062.90
210102	Нэмэгдэл	0.00	0.00	6475500.00	6293434.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	0.00	6023600.00	5453811.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	4238800.00	3880801.48
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	446200.00	432565.52
210203	ҮОМШО-ний даатгал	0.00	0.00	357000.00	346051.83
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	89200.00	70933.09
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	892400.00	723459.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	0.00	36439600.00	36293804.40
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	539600.00	397198.40
210302	Түлш, халаалт	0.00	0.00	35900000.00	35896606.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	0.00	325000.00	325000.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	60000.00	60000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	100000.00	100000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	90,000.00	90,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	-	380,000.00	379,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	80,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	-	-	300,000.00	299,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-	58,000.00	40,000.00
210702	Дотоод албан томилолт	-	-	58,000.00	40,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-	3,008,000.00	1,900,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	1,900,000.00	1,900,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	200,000.00	200,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	200,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	200,000.00	200,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-	-	<b>1,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-	-	1,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	1,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	91,053,300.00	91,053,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	90,553,300.00	90,553,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	90,553,300.00	90,553,300.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-	500,000.00	500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	500,000.00	500,000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	-	-	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	-	6.00	4.00
620001	Удирдах ажилтан	-	-	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	3.00	3.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант онд нэмэлт дансаар гүйлгээ хийгдээгүй болно.

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хялганат тосгоны Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хялганат тосгоны Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хялганат тосгоны Соёлын төв нь “Санхүүгийн тайлангийн зорилго нь хөрөнгө, эх үүсвэр, өр төлбөрийг багтаасан санхүүгийн үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээллээр дээд шатны байгууллага, төрийн сан, байгууллагын удирдлагыг хангахад оршино” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хялганат тосгоны Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 105423.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1581.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1106.9 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хялганат тосгоны Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мян.төг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	0	0	0
Бараа материал	5632.9	4365.4	1267.5
Үндсэн хөрөнгө	125618.6	126827.2	-1208.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>87307.4</b>	<b>75641.2</b>	<b>11666.2</b>
<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Хуримтлагдсан үр дүн	-280989.8	-212716.8	-68272.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>87307.4</b>	<b>75641.2</b>	<b>11666.2</b>

**Авлага:** Өмнөх оны авлага буюу оны эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 5632.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 4365.4 мянган төгрөг болсноор 1267.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бичиг хэргийн материал 151.3 мянга, аж ахуйн материал 257.0 мянга, түлш шатахуун 100.0 мянга, засварын материал 855.3 мянган төгрөг нийт 1591.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 125618.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 126827.2 мянган төгрөг болж өмнөх оноос 1208.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр программ хангамж 1000.0 төгрөг, хандив тусламжаар буюу үнэ төлбөргүй 208.5 мянган төгрөг нийт 1208.5 мянган төгрөгийн худалдан авалт хийжээ.

**Өр төлбөр:** Өглөгийн дансанд оны эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэлгүй байна. Санхүү байдлын, орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлага зэргийг тодруулж тайлагнасан болно.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Хялганат тосгоны Соёлын төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 91261.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 91261.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 91261.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 36293.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 54759.5 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Хялганат тосгоны Соёлын төв нь 2021 он орон нутгийн төсвөөс 90553.3 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөг нийт 91053.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 91261.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 90553,3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 500,0 мян, төгрөг нийт 91053,3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 89418.3 мянган төгрөгийг зарцуулж 1843.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хялганат тосгоны Соёлын төв нь 2021 онд нэмэлт дансаар гүйлгээ хийгдээгүй тул тайлан гаргаагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 126827.2 мянган төгрөг болж 1208.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгө оруулалтаар 1000.0 мянган төгрөгийн Си Ти Эйс ХХК-ны программын шинэчлэл, Булган аймгийн төв номын сангаас 208.5 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй шилжиж ирсэн нь нэмэгдсэн байна.

Санхүүгийн тодруулга тайланд оны эцэст авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч хугацаа хоцроож мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 1 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн 54 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эд хөрөнгийн тооллогын эцсийн үлдэгдлийг санхүүгийн тайлантай тулгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

#### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа гараагүй болно.

#### 4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

#### 4.4 Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хялганат тосгоны Соёлын төв	0	0	0	0	0	0	0	0	0	0

/сая/төгрөгөөр/